

The Defacto Gazette

МОНГОЛ, АНГЛИ ХЭЛ ДЭЭР ДОЛОО ХОНОГ ТУТМЫН СОНИН №. 10 | ЛХАГВА, 2017.08.30 WWW.DEFACTO.MN

НИЙТЛЭЛ

Авлига хэмээх хорт хавдраас АВРАГДАХ нь . 2-р нүүр

ЯРИЛЦЛАГА

С.Ариун,
"Монголын холбоос" байгууллагыг үүсгэн байгуулагч . 3-р нүүр

ТОЙМ

МАН-ын хагарал юунд хүргэх вэ?
Багш нарын ажил хаялт . 7-р нүүр



№394

Д.Жаргалсайхан
www.jargaldefacto.com

Авлига хэмээх хорт хавдраас АВРАГДАХ нь

Авлига нь монголын нийгэмд туссан хорт хавдар болчихлоо гэж жил хагасын өмнө би нийтлэл бичээд авлигатай тэмцэж буй Хятадын жишээг дэлгэрэнгүй дурдсан <http://www.ikon.mn/opinion/n5i> билээ. Түүнээс хойш энэ хавдар төр засгийн эд эсэд ямар өндөр хурдаар газар авч буйг 2016 оны сонгууль, дараа нь байгуулсан төр засгийн бүтцээс харж болно. МАН-даа хандивласан мөнгөнийхээ хэрээр төр засгийн өндөр албан тушаалууд эрэмбэлэгдэн борлогдов. Алдарт бичлэгт нь төлөвлөгдсөн 60 тэрбум төгрөг бүрдсэн байх аа.

Эрдэнэтийн 49 хувийг хуйвалдан авахдаа, ХХБ-ны эзэн нь зохиомол гэрээгээр, таван хүнийхээ нэр дээр хадгаламж эзэмшигчдийнхээ мөнгөнөөс 500 сая доллар зувчуулж, шилжүүлснийг УИХ-ын шалгалт тогтоосон ч, төдөлгүй энэ тухай яриа замхрав. Нөгөө улс төрчид, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд лав

сайн дураараа таг чиг болчихоогүй нь мэдээж.

Саяхны Ерөнхийлөгчийн сонгуульд МАН, төсвийг оролцуулаад 370 тэрбум төгрөг зарцуулсан тухай гишүүд нь мэдээлэв. АН дор хаяж энэ мөнгөтэй дүйцэхүйц хөрөнгө зарцуулж л ялсан. Энэ их мөнгө хаанаас, яагаад гарсан, яаж эргэн төлөгдөхийг улс төрчид л зөвхөн мэднэ. Ардчилсан Монголд гагцхүү илүү их мөнгөтэй нам нь сонгуульд ялдаг болов.

Хорт хавдраа эмчлэх нь

Сэргэн мандалтын соён гэгээрүүлэгч, Италийн улс төрч Никола Макиавелли авлигыг анх Ромын хууль зүйд томьёолсныг тогтоожээ. Макиавелли авлигыг өвчинтэй адилтгаж, эхэндээ таньж мэдэхэд хэцүү ч эмчлэхэд амар, эцэстээ бол таньж мэдэхэд амархан ч, эмчлэх бараг боломжгүй гэжээ.

Авлига нь ухамсарт нөлөөлж, эцэстээ хувь хүнийг мөхөлд хүргэдэг.

Сэтгэлзүйчид авлигыг мөрийтэй тоглоомтой зүйрлэдэг. Авлига нь “тоглогчийн” адреналинийг нэмдэг сэргээш гэжээ. Таашаалаа дахин авах гэж аюултай үйлдлээ давтсаар. “Би авлига авсан ч, баригдаагүй, дахиад нэг авчихъя, яахыг нь харъя” гэх болдог гэнэ. Авлига авагчид өнгө, дүрсээ чадмаг өөрчилж сурдаг. Төрийн ажилд орохдоо авлига авна гэж хүн бүр эхлээд боддоггүй. Төрдөө шударга зүтгэе гэж, ялангуяа залуучууд зорьдог. Гэвч тогтолцоо нь өөрөө авлигатай болохоор, өөрийн эрхгүй авлигач болдог. Манайд авлигач бол эхлээд намдаа бэлтгэгддэг. Төрийн эрхийг сонгуулиар авдаг цорын ганц байгуулал болох улс төрийн нам авлигатай болчихоор, төдөлгүй төр засаг нь авлигын намагт “шигддэг”.

■ Үргэлжлэл 2-р нүүрт

99118301, 99118375, 99106507

ЭЗЖИЛ ХУВААРЬТ ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ҮНЭГҮЙ

ҮЙЛДВЭРИЙН БАТАЛГАА:
3 жил буюу 60,000 км / 5 жил 100,000 км

УРЬДЧИЛГАА:
0-50%

ХУГАЦАА:
60 сар

ҮНДСЭН ҮНЭ: 174,000,000₮

ХАСЛИЗИНГ

FORD EXPEDITION	20% ХУГАЦАА	30%	40%	50%
УРЬДЧИЛГАА 1%/	34,800,000₮	52,200,000₮	69,600,000₮	87,000,000₮
САРЫН ТӨЛӨЛТ	4,355,473₮	3,296,000₮	2,754,000₮	2,295,000₮

WAGNER ASIA AUTOMOTIVE LLC

Ford Go Further

emart

ХОРООЛОЛ САЛБАР

ТУН УДАХГҮЙ



№394

Д.Жаргалсайхан
www.jargaldefacto.com

Авлига хэмээх хорт хавдраас АВРАГДАХ нь

Эхлэл 1-р нүүрт

Манай хууль журам бодит байдал дээр хэрэгждэггүй, хэрэгжүүлэх ч сонирхолгүй байдаг. Нам хувь хүн болон хуулийн этгээдээс авах хандивийн дээд хэмжээг нэг болон арван сая төгрөгөөр арваад жилийн өмнө тогтоосон нь бодит байдалд эхнээсээ л нийцэхгүй байсан.

Санхүүжилт олох үүрэгтэй намын дарга нэг компаниас 100 сая төгрөг аваад үнэнээр нь тайлагнах хэцүү, байх хэцүү болдог. Ойрын хүрээний цөөн хүндээ мэдэгддэг, яваандаа мэдэгдэхээ ч больсоор, нэг л мэдэхэд асар их мөнгө, хөрөнгө захирдаг, мафийн “босс” болдог.

Санхүүжилт олох үүрэгтэй намын дарга нэг компаниас 100 сая төгрөг аваад үнэнээр нь тайлагнах хэцүү, байх хэцүү болдог. Ойрын хүрээний цөөн хүндээ мэдэгддэг, яваандаа мэдэгдэхээ ч больсоор, нэг л мэдэхэд асар их мөнгө, хөрөнгө захирдаг, мафийн

“босс” болдог.

Сонгуульд хэнийгээ хаана дэвшүүлж, яаж сурталчилж, ялуулахаа намын дарга, мөнгөний эзэн шийддэг. Намын дотоод ардчилал алга болж, хэн хичнээн мөнгө оруулсан, босгосноороо

ялгагдан фракц болж, нөгөө фракцын засгийн газрыг унагаж, эрх мэдэл авахыг зорьдог. Зарчимд биш мөнгөнд суурилсан, улс төрийн нам дотроосоо өөрөө өөрийгөө ийнхүү мөхөлд хүргэдэг. Яг энэ замаар явж ирсэн МАНАН өнөөдөр мөхөх, мандахын уулзвар дээрээ иржээ. Хаашаа эргэхээ шийдэхээр МАН эдүгээ ид тэмцэлдэж байна.

Бид хамгийн түрүүнд, улс төрийн намуудын санхүүжилтийг ид тод болгохгүйгээр, Их хуралд авсан суудлаар нь төсвөөс санхүүжүүлээд, иргэд нь хянахгүйгээр Монгол энэ хорт хавдраасаа салахгүй ажээ.

Хорт хавдраас сэргийлэх нь

Авлига нь цацраг туяатай адилхан учир атомын бөмбөгнөөс аюултай. Энэ туяа харагдахгүйгээр, хүний биед шингэж, аажмаар хорт хавдар үүсгэдэг. Эрүүл мэндээ тогтмол хянаж, арчилдаггүй хүн хорт хавдраа илрүүлэхэд хэцүү. Хорт хавдар хамгийн сүүлчийн үе шатандаа илэрдэг, тэр хүртэл хүн өвдсөнөө мэддэггүй. Эрхтэн дотор хорт хавдрын эсүүд эрүүл эсүүдээ идэж устгасаар, бие хүч тэнхээгээ алдсаар, эцэст нь өвчинтэйгөө тэмцэж чадахаа больж нас бардаг. Хэрэв авлига нь өвчин юм бол түүнд эмчилгээ байх учиртай.

Тодорхой арга хэмжээ авснаар өвчнөөс урьдчилан сэргийлдэг. Авлигын хувьд хамгийн түрүүнд хуулийг хүндлэх хүмүүжлийг иргэддээ олгох шаардлагатай. “Хууль чамд таалагдаж, эсвэл таалагдахгүй байж болно. Аль ч тохиолдолд, чи хуулийг мөрдөх ёстой” гэдгийг хүн бүрийн толгойд гүн суулгах хэрэгтэй.

Манай нийгэм хүүхдийг хар багаас нь авлигад бэлдэж байна. Анги, сургуульд элсэх, төгсөх, сайн сурахын тулд багшдаа “бэлэг” өгдөг боллоо. Үнэхээр талархмаар бол чин сэтгэлээсээ баярлалаа гэхэд л уг нь болмоор. Бид талархахдаа, эргээд надад ямар ашигтай байхыг тооцдог болжээ. Авлигын хөрс нь бидний ухамсарт шигджээ.

Авлигын хор уршгийг ойлгож, ямар ч хэлбэрийг нь жигшдэг болохуйц нийгмийн харилцааг бүрдүүлэх цаг болжээ. Анагаах ухааны хэллэгээр, авлигын эсрэг

нийгмийн дархлааг бүрдүүлэх, хөгжүүлэх шаардлагатай байна. Өвчнөөс урьдчилан сэргийлэх нь, эмчлэхээс хямд байдаг.

Бид хамгийн түрүүнд, улс төрийн намуудын санхүүжилтийг ид тод болгохгүйгээр, Их хуралд авсан суудлаар нь төсвөөс санхүүжүүлээд, иргэд нь хянахгүйгээр Монгол энэ хорт хавдраасаа салахгүй ажээ

Авлига нь бидний ухамсарт байгаа нийгмийн үзэгдэл учраас хувь хүний хүмүүжил, төлөвлөөр өөрчлөх боломжтой. Өнөөдөр бид иргэдийнхээ хуульзүйн боловсролыг нэмэгдүүлэх, нийгмийн боловсролтой, боломжтой хэсгээ авлигын эсрэг тэмцэх үр шимтэй хөрс болгоход анхаарах нь чухал байна.

Авлигач нартай тэмцэхээс гадна, авлига гарах үндэс суурийг нь арилгах ёстой. Жоомоо устгахаас гадна, тэднийг үржүүлээд байгаа хоол хүнсний хог хаягдлаа тогтмол цэвэрлэх цаг болжээ.

Авлигатай тэмцвэл ганц хоёр нам л алга болно, тэмцэхгүй бол Монгол улс маань алга болно. Та алийг нь сонгох вэ?



WORLD WINE

БГ Дүүрэг, 3-р хороо, Нарны гүүрний баруун талд, WW Center

Утас: 7577-0701, 9104-0202

Да-Ба 10⁰⁰-20⁰⁰
Бя-Ня 11⁰⁰-19⁰⁰

ДЕФАКТО ЯРИЛЦЛАГА

Анх музей нь түүх соёлын биет болон биет бус өвийг хадгалах, хүмүүст үзүүлэх зорилготой байсан бол одоо мэдлэг, боловсрол, соёлыг олон нийтэд олгоход оршиж байна



С.Ариун

“Монголын холбоос” байгууллагыг үүсгэн байгуулагч

Ж: Та уг ‘Mongolia Connections’ байгууллагаараа олон жил Монгол-Америкийн хооронд хүмүүсийг холбож ялангуяа музейтэй холбоотой нэлээд их ажил хийж байна. Энэ талаараа та танилцуулна уу. Сүүлийн үед ямар онцлог зүйлс болж байна вэ?

С.Ариун: 2012 онд Нью-Йорк хотод ‘Mongolia Connections’ байгууллагаа үүсгэн байгуулсан. Нью-Йорк хот нь санхүү, эдийн засгийн төвөөс гадна соёл урлагийн маш том төв. ‘Mongolia Connections’ байгууллагаараа Монгол-Америк хоёр улсыг холбох гүүр болохоос гадна бизнесийн байгууллагуудад зөвлөгөө өгөх мөн соёл урлаг, аялал жуулчлал, ноолуурын чиглэлээр ажилладаг байгууллагуудад

монголын талаас зөвлөгөө өгөх, Америкаас бол Монгол талруугаа зөвлөгөө өгөх зорилготой байгуулсан. Нью-Йоркод бизнесийн чиглэлийн монголтой хамтран ажилладаг байгууллага цөөхөн. Ихэнх тохиолдолд соёл урлаг, аялал жуулчлал үүн дотроос музейгээр дамжуулан соёл боловсролын хөтөлбөр хийх саналууд ирж байсан. Би хүний нөөцийн чиглэлээр ажиллаж байсан учраас манайд нэн хэрэгцээтэй байгаа соёл урлагийн менежмент үүнд музейн менежментийн чиглэлд анхаарал хандуулан үүн дотроо байгууллагын хөгжлийн мэргэжилтэн гэдэг утгаараа байгууллагыг хөгжүүлэхийн тулд ажилчдын чадварыг сайжруулах шаардлагатайг олж харсан. Мөн

музейгээр дамжуулан олон нийт, хүүхэд залуучуудад зориулсан боловсролын хөтөлбөр маш чухал үүрэгтэйг өөрөө музейд ажиллаж байсны хувьд олж харсан. Ингээд Монголын музейг Америкийн музейтэй холбож, музейн ажилчдыг америкт мэргэжил дээшлүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Ж: Энэ талаараа илүү тодорхой ярьж өгөөч.

С.Ариун: 2012 оноос хойш олон ажил хийсээр явж байна. “Монголын Музейн Холбоо”-г хамтран ажилладаг музейн ажилчид маань байгуулсан. Уг холбооны шугамаар “Америкийн Музейн Холбоо”-той анх холбогдоход тухайн үед “Америкийн Музейн Холбоо” “монголоос хүн огт авч байгаагүй, бид ОУ-н музейн харилцаа холбоогоо сайжруулах зорилготой байна, бидэнд монголоос хүн холбож өгөөч” гэсэн санал тавьж байсан. Үүний дагуу жилдээ нэг хүн АНУ руу мэргэжил дээшлүүлэхээр явуулж байхаар болсон. “Америкийн Музейн Холбоо” нь удирдах ажилтныг илүүтэй явуулаач гэж хүсэлт тавьж байсан.

Ж: Энэ ажлыг тань монгол тал яаж хүлээн авч байна вэ?

С.Ариун: Монголын талаас голдуу тодорхойлолт гаргаж өгөх болон бусад бичиг баримтын асуудалд туслалцаа үзүүлдэг. Миний зүгээс бүрэн хэмжээний тэтгэлгийг олж хүний нөөцийн мэргэжлийн хүн учир хүмүүсийнхээ анкетыг хянадаг. Ингээд “Америкийн Музейн Холбоо” гурван хүний нэр хүлээн авсны дараа эцсийн шийдвэрийг гаргадаг. Одоогоор таван хүн хүлээн авсан ба үүнд орон нутгаас мөн багтаж байгаа. Би цаашид боловсролын хөтөлбөрийн ажилтнуудыг явуулах зорилготой байгаа.

Манайханд гадаад хэлний чадварын асуудал гардаг нь их хүндрэлтэй байдаг.

Ж: АНУ музейгээрээ дамжуулж боловсролын салбартаа танин мэдэхүйн томоохон үйл ажиллагаа зохион байгуулж үүнд нь сургуулийн хүүхдүүд заавал хамрагдах ёстой байдаг. Хүүхдүүдэд музей үзүүлж байгаа гол шалтгааныг та яаж харж байна вэ? Монголын боловсролын салбарт ч мөн адил музей яагаад гол үүрэг гүйцэтгэх ёстой вэ?

С.Ариун: Үүнд америкийн музейн түүхийг товчхон ярья. Учир нь АНУ анх музейгээ байгуулахдаа судалгаа шинжилгээ буюу олон нийтэд соёлын өв, баримт бүхий түүхэн зүйлсийг таниулах зорилготойгоос гадна эрдэмтэд, судлаачид нь тэр бүхнийг судалдаг. Уг зорилгын хүрээнд боловсролын хөтөлбөрийг анхнаас нь хэрэгжүүлж байсан. Бименежментийн сургалтанд сууж байсан учир Европын музейн талаар мөн мэднэ. Европын музей нь АНУ-ын музейтэй харьцуулахад анх хаад, ноёд дээд зиндааны хүмүүсийн цуглуулгыг гайхуулах, үзүүлэх зорилготой байгуулагдсанаараа ялгаатай. Иймд АНУ нь анхнаасаа боловсролын хөтөлбөр нь олон нийтэд чиглэсэн байсан учир өндөр түвшинд хүрсэн. Музейгээр тухайн орны соёлын биет ба биет бус бүх өв хадгалагдаж судлагдаж байдаг. Бид бүгд эрдэмтэн, судлаачид биш учраас уг материалуудыг энгийн хүмүүс, хүүхэд залуучуудад хүргэхэд энгийн хэллэгтэй болгоход боловсролын ажиллагааны гол зорилго оршдог. Үүгээрээ дамжуулж олон нийтийг боловсруулж соёлын мэдлэг олгодог. Нью-Йорк нь дэлхийн түүхийн төв гэдгээрээ дэлхийн түүхийг залуучууддаа сургаж байна. Ингээд бусад орны соёлыг мэдэж авна гэдэг нь тухайн оронтой харилцах харилцаа, худалдаа, эдийн засаг, нийгэм болоод соёлын асуудал руу орж байна гэсэн үг. Монголд музейнүүд сүүлийн жилүүдэд боловсролын хөтөлбөртэй болсон, энэ үйл ажиллагаа идэвхтэй явагдаж

байгаа. Гэвч ач холбогдлыг нь төдийлөн сайн ойлгохгүй байна. Анх музей нь түүх соёлын биет болон биет бус өвийг хадгалах, хүмүүст үзүүлэх зорилготой байсан бол одоо мэдлэг, боловсрол, соёлыг олон нийтэд олгоход оршиж байгаа юм.

Ж: Музейн санхүүжилт хэрхэн хийгддэг вэ? Яаж үүнийг зохицуулдаг вэ?

С.Ариун: Хэдийгээр би яг музейн чиглэлээр ажиллаагүй ч сүүлийн үед музейн менежменттэй холбоотойгоор материалуудтай танилцаж судалгаа хийж байна. “Metropolitan Museum of Art”-ын боловсрол хөтөлбөрт сайн дураараа ажиллаж бүх чөлөөт цагаа музейг судлахад зориулж байна. Мөн “Rubin Museum of Art”-ын олон нийтийн хөтөлбөр дээр ажиллаж байна. Нью-Йорк хот гэхэд 175 музейтэй, музейдээ маш их ач холбогдол өгдөг. Мэдээж олон жилийн туршлагатай учир шууд монголтой харьцуулах боломжгүй. Музейд ихэнх цагаа өнгөрүүлэх сонирхолтой орчин, нөхцөл байдлыг нь бүрдүүлдэг. Олон цаг байх учир дизайн гоё, орчин тухтай, нас насны буюу төрөл бүрийн программууд байна. Боловсролын хөтөлбөр гэхэл д олон нийт, хүүхэд залуучууд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг бүгдэд нь зориулсан байдаг.

Санхүүжилтийн хувьд миний одоогийн ойлгож байгаагаар гурван газраас бүрддэг. Муждаа харьяалагддаг музейнүүд нь Холбооны ЗГ, мужаасаа тодорхой хэмжээний мөнгө авна, хоёрдугаарт хөрөнгө босгоно, гуравдугаарт гишүүнчлэл. Ингээд үндсэн 3 эх үүсвэрээс санхүүжиж байна.

Ж: Музейн гишүүнчлэлийн талаар ярилцъя. Хэн гишүүн болдог вэ?

С.Ариун: Миний ойлгож байгаагаар Америкийн музей нь зах зээлийн системээр ажиллаж байна. Бид уг системд шилжээд 25 жил болж бизнес, эдийн засаг, компаниуд

хөл дээрээ зогссон. Харин одоо соёл урлаг, боловсролд анхаарах цаг болсон. Манай музейнүүд улсын өмч учраас соёлын байгууллагуудад хөрөнгө босгоход ашиг сонирхлын асуудал үүсдэг. Миний ойлгож байгаагаар Америкийн музейнүүдийн захирлууд нь соёлын салбартай холбоотой хүн байхаас гадна хамгийн гол нь хөрөнгө босгох чадвартай хүн байх ёстой байдаг. Тухайн захирал хөрөнгө өсгөснөөрөө урамшууллаа авна мөн мэргэжлийн ажилчдаар багаа бүрдүүлж төрөл бүрийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг. Гишүүнчлэлийн асуудал нь тухайн музейн зорилгоос хамаардаг. Хэдийгээр музей бүр боловсрол олгож байгаа ч өөр өөрийн гэсэн зорилготой байдаг. Жишээ нь урлагийн музей, шинжлэх ухааны музей, хүүхдийн музей гээд өөр өөр зорилготой байдаг. Тухайн сонирхлын чиглэлээрээ гишүүн болдог. Жишээ нь би Рубин болон Метрополитан зэрэг музейнүүдэд давхар гишүүнчлэлтэй. Гишүүнчлэл нь жилийн турш үнэгүй үзэх, нэг зочин үнэгүй авч орох, музей доторх ресторан, кафе зэрэг үйлчилгээний газруудад хөнгөлөлттэй үнээр үйлчлүүлэх, аливаа дараалалд зогсохгүй байх, үзэсгэлэн гарахад нээлтийг нь үзэх зэрэг давуу талуудтай. Энэ системийг монголд хэрэгжүүлэх талаар би төлөвлөж байгаа.

Ж: Музей дотор үйл ажиллагаа зохион байгуулах нь тухайн музейд сурталчилгаа болж өгөх мөн зохион байгуулж буй үйл ажиллагааны нэр хүндийг нэмэгдүүлэх зэрэг давуу талуудтай. Монголд сүүлийн үед энэ хандлага гарч байна. Энэ хандлагыг та яаж харж байна вэ?

С.Ариун: Энэ бол маш зөв эхлэл, үүнийг би их дэмжиж байгаа. Тухайлбал Чойжин ламын сүм музей нь шөнийн музей гэдгээрээ бренд болж байна. АНУ-д ч бас музейнүүд том бренд үйл ажиллагаатай байдаг. Уг үйл ажиллагаагаа хөрөнгө босгох болон гишүүнчлэлээ тэлэх зорилготойгоор зохион байгуулдаг.

Ж: Шөнийн музейн талаар ярьж өгөөч.

С.Ариун: Оройн цагаар музей хаалгаа нээж үзүүлэхийн хажуугаар соёл урлагийн тоглолтууд зохион байгуулагддаг. Занабазарын нэрэмжит Дүрслэх Урлагийн музейн хувьд тогтсон олон нийтийн хөтөлбөрүүдтэй болсон. Жишээ нь эртний урлагийн талаар лекц зохион байгуулж байна. Урлагийн болон түүхийн боловсролыг олгоход шат дараалалтай байхын тулд Занабазарын нэрэмжит Дүрслэх Урлагийн музейг эхэлж үзсэний дараа Модерн Арт Галлерейг үзвэл



Дэлгэрийн Уянга,
Хуульч

2017 оны 8-р сарын 23 буюу өнгөрсөн Лхагва гарагт Монгол Ардын Намын (МАН) Улсын Их Хуралд суудалтай 30 гишүүн Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатыг огцруулах замаар Засгийн Газрыг тараах санал тавилаа. Энэ үйл явц нь МАН 2016 оны 7-р сараас хойш Улсын Их Хуралд 65 суудалтайгаар парламент, Засгийн Газрын аль алиныг нь хянаж байгаа үед өрнөж байна. Ерөнхий сайдыг огцруулах асуудлыг Улсын Их Хурал ирэх өдрүүдэд хэлэлцэх болно.

Огцруулах саналыг Ардчилсан намаас нэр дэвшигч Х.Баттулга Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсоноос хойш хэдхэн долоо хоногийн дараа гаргалаа.

Гүйцэтгэх засаглалын эрх мэдлийг Ерөнхий Сайд ба Ерөнхийлөгч гэсэн хоёр тусдаа институтэд салгаж өгснөөс үүдэлтэй Засгийн Газрын тогтворгүй байдлаас болж Монгол Улс хохирч байгаа билээ. Ж. Эрдэнэбат Улсын Их Хурлын санал хураалтаар албан тушаалаа энэ удаад авч үлдлээ ч гэсэн засаглалын суурь доголдол хэвээр үлдэх юм. Засаглалын системээ

тохиромжтой. Музейн үйл ажиллагаа явуулж буй хүмүүс бужигнаж байж “амьд” байхаас биш зүгээр нэг агуулах маягаар байж болохгүй.

Ж: Та Рубин музейн талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу?

С.Ариун: Рубин бол хувийн музей. Манайд ч бас сүүлийн үед хувийн музейнүүд хаалгаа нээж өрсөлдөөн бий болж байгаа нь их зөв юм. Рубин музей анх 2008 онд нээгдсэн. АНУ-д хөрөнгө чинээтэй хүмүүс соёл урлаг, түүхийн цуглуулгатай болж музей нээдэг.

Шелли Рубин гэх гэр бүлийн хоёрын сонирхол Буддист Арт чиглэлд байсан ба 3000 орчим цуглуулгаараа өмнө нь Рубин музей дэлгүүр байсныг авч музей болгосон. Үүгээрээ тухайн орчныг хүртэл соёлтой болгож байгаа юм. Рубин музейд монголын хувьд одоогоор “Performance Art” зохион байгуулахад нээлттэй байгаа.

2017.07.29

Ярилцлагын бүрэн эхийг
<http://bit.ly/2wYAXW6>
холбоосоор үзнэ үү.

Тогтвортой Засгийн Газартай байх боломж

дахин эргэцүүлж үзэж, хэлэлцэж, шинэчлэх шаардлага урьд өмнөхөөс илүүтэйгээр бий болжээ.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл

Улсын Их Хурлын дарга М.Энхболдын байгуулсан ажлын хэсэг Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулсан билээ (УИХ-ын 2017 оны 6-р сарын 2-ны №39 тогтоол). Тус төслийн тухай олон нийтийн хэлэлцүүлгийг өдгөө орон даяар зохион байгуулж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч нь хууль санаачлах, Засгийн Газарт чиглэл өгөх Үндсэн хуулийн эрхтэй. Ерөнхийлөгч нь Ерөнхий Сайдг томилох, чөлөөлөх эрхгүй тул Засгийн Газрыг албан ёсоор тэргүүлдэггүй. Ерөнхий Сайд нь үйл ажиллагаагаа Улсын Их Хурлын өмнө хариуцдаг.

Бодит амьдрал дээр Ерөнхийлөгчийн институт нь Засгийн Газартай зэрэгцэн орших гүйцэтгэх засаглалын хэлбэр болж хувьсжээ. Үүнийг 1992 оны Үндсэн хуулийг боловсруулагчид хүсээгүй

нь тодорхой.

Ерөнхийлөгч нь ард түмнээс шууд сонгогддог тул түүний эрх мэдэл нь бүх ард түмний дэмжлэгээр баталгааждаг. Энэ нь Ерөнхийлөгчийг хүчтэй, орон даяар хамгийн их нөлөөтэй улс төрийн удирдагчийн байр сууринд аваачдаг. Харин Ерөнхий Сайд хувьд түүнийг Улсын Их Хурал томилдог.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр гүйцэтгэх засаглалын салбарт хамаарах Ерөнхийлөгчийн эрх мэдлийг хязгаарлахыг зорьжээ. Төслөөр хууль санаачлах, Засгийн Газарт чиглэл өгөх Ерөнхийлөгчийн эрх мэдлийг хассан байна.

Төсөлд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2020 оны 7-р сараас үйлчилж эхлэхээр заажээ.

Үзэл бодол

УИХ-ын 2017 оны 6-р сарын 2-ны №39 тогтоолд хавсаргасан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл нь Ерөнхийлөгчийн сонгуулийн арга хэлбэрийг өөрчлөх зорилгогүй байна. Төслийн дагуу Ерөнхийлөгч ард түмнээс шууд сонгогдсон хэвээр байх юм.

► Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг УИХ-аар баталсан ч гэсэн монголын засаглалын тогтолцоонд бий болсон “түгжрэл” хэвээр байсаар байх болно. Энэхүү түгжрэлийг даван туулахын тулд асуудлыг өргөн хүрээнд авч үзэх шаардлагатай.

Өнөөгийн тогтолцоо нь хоорондоо өрсөлдсөн улс төр, эдийн засгийн цөөн бүлэглэлийн гарт засгийн эрхийг байлгаж, тэдний эвсэл болон эвдрэлийн аясаар төр засаг, нийгэм “савлаж” байгаа билээ. Энэхүү “ардчилсан бус” байдлаас гарахын тулд нэгдүгээрт хорь орчим тооны УИХ-ын гишүүн

Парламентийн ардчиллыг бэхжүүлэхийн зэрэгцээгээр Ерөнхийлөгчийн институтийг нэг бол Герман шиг цэвэр билгэдлийн шинжтэй болгох эсвэл Франц шиг гүйцэтгэх засаглалд бодитой, ойлгомжтойгоор шилжүүлэхгүй бол Монгол Улс дахь Засгийн газрын тогтворгүй байдал үргэлжилсээр байх болно

Хоёрдугаарт, УИХ-ын гишүүдийн тоог жинтэй нэмсэн тохиолдолд л “давхар дээл” буюу УИХ гишүүн Засгийн Газрын гишүүн давхар байх боломжтой. Хорь орчим тооны гишүүн санал нийлбэл бүх нийтээр мөрдөх ёстой хууль баталж байгаа өнөөгийн тогтолцоонд “давхар дээл” нь эрх мэдлийн төвлөрөл бий болгож, Засгийн Газрыг байнга унагаж, дараагийн ээлж “хоолондоо орох” тэмцлийг өдөөж байна.

Гуравдугаарт, УИХ-ын гишүүний хууль санаачлах эрхийг дорвитой хязгаарлаж, хууль санаачлах болон хуулийн төсөл боловсруулах ажлыг Засгийн Газарт төвлөрүүлэх тогтолцоо шаардлагатай байна. Өнөөгийн тогтолцоонд УИХ-ын гишүүд хэд гурваараа нийлж хууль санаачилдаг. Энэ нь үндсэн суурь тогтолцоог эвдсэн, гадаадын янз бүрийн улсаас гаралтай сэтгэлгээ, тогтолцоог суурь тогтолцоонд “шахаж”, тогтолцоог улам ойлгомжгүй, замбараагүй болгож байна. Ийм нөхцөлд эдийн засгийн явцуу сонирхол бүхий бүлгүүдийн хуулийн лобби хурцдаж, улс орны тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх нэг хүчин зүйл болох боломжтой.

Зарчмын хувьд гүйцэтгэх, хууль тогтоох, шүүх засаглал гэсэн засаглалын гурван салааны ялгаа, заагийг илүү сайн тодорхой болгох хэрэгтэй байна. Ингэхдээ тогтолцоо нь албан тушаалтнуудын өрсөлдөөн, наймаа бус харин улс төрийн манлайлал бий болгох нөхцлийг бүрдүүлэх ёстой. Улс төрийн манлайлал гэдэгт гүйцэтгэх засаглалын тэргүүн танилцуулсан бөгөөд парламентын олонхын дэмжлэгт найдах боломжтой үзэл баримтлал, чиг шугамыг ойлгож байна.

Өнөөгийн нөхцөл байдлыг эргэцүүлж үзвэл Монгол Улс нь Францтай ойролцоо хагас Ерөнхийлөгчийн засаглалтай тогтолцоонд бүр мөсөн шилжих боломжтой юм. Францад Ерөнхийлөгчийг ард түмнээс шууд сонгодог. Парламентын сонгуулийг Ерөнхийлөгчийн сонгуулийн дараахан буюу бараг нэгэн зэрэг явуулдаг учир Ерөнхийлөгчийн албыг нэг намын нэр дэвшигч авч, парламентын олонх өөр нэг нам болох боломж Францад үндсэндээ байхгүй байдаг. Францын Ерөнхийлөгч нь Ерөнхий Сайдг томилж, ажлаас нь чөлөөлөх эрхтэй.

Тэрээр Засгийн Газрыг тэргүүлдэг учир гүйцэтгэх засаглалын тэргүүн маргаангүй мөн юм.

Өөр нэг боломж нь МУ-ын 1992 оны Үндсэн хуулийн анхны үзэл баримтлалыг илүү тодорхой болгох замаар Германтай ойролцоо тогтолцоонд бүр мөсөн шилжих явдал юм. Германд Ерөнхийлөгчийг ард түмнээс шууд бус харин парламентаас сонгодог. Германд Засгийн Газрыг Канцлер (Ерөнхий Сайд) тэргүүлдэг. Энэ тогтолцооны

ж и н х э н э
м а н л а й л а г ч ,
Энэ нь
ү н д с э н с у у р ь
т о г т о л ц о о г
э в д с э н ,
г а д а а д ы н я н з
б ү р и й н у л с а а с
г а р а л т а й
с э т г э л г э э ,
т о г т о л ц о о г
с у у р ь
т о г т о л ц о о н д
“ ш а х а ж ” ,
т о г т о л ц о о г
у л а м
о й л г о м ж г ү й ,
з а м б а р а а г ү й
б о л г о ж б а й н а

УИХ-ын 2017 оны 6-р сарын 2-ны №39 тогтоолд хавсаргасан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл нь дээр дурдсан парламентын ардчиллыг бэхжүүлэх асуудалд ямар нэг дорвитой өөрчлөлтийг санал болгохгүй байна. Төслийн дагуу Ерөнхийлөгч хэдийгээр хууль санаачлах, Засгийн Газарт чиглэл өгөх эрхгүй болох хэдий ч бүх ард түмнээс шууд сонгогдсон удирдагчийн хувьд тэрээр “хөшигний ард” ч гэсэн нөлөө бүхий байсаар байх болно.

Парламентийн ардчиллыг бэхжүүлэхийн зэрэгцээгээр Ерөнхийлөгчийн институтийг нэг бол Герман шиг цэвэр билгэдлийн шинжтэй болгох эсвэл Франц шиг гүйцэтгэх засаглалд бодитой, ойлгомжтойгоор шилжүүлэхгүй бол Монгол Улс дахь Засгийн газрын тогтворгүй байдал үргэлжилсээр байх болно.

ДЕФАКТО ТОЙМ



Ням гараг бүр VTV-ээр 19 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл: 2017.08.27-ны дугаар

МАН-ын хагарал юунд хүргэх вэ?

МАН-ын хагарал дээд цэгтээ хүрсэн байна. УИХ-д 65 суудалтай МАН-ын 30 гишүүн ЗГ-ыг огцруулах асуудлаар хэлэлцэхийг УИХ-д өргөн бариад байна. УИХ-ын дарга тодорхой бус эсвэл хүндэтгэх шалтгаанаар гадаадад явсан байна. Уг хүсэлтийг УИХ-ын дэд дарга хүлээж аван хариу өгөөгүй байна. Шадар сайд албан тушаалаасаа огцрох хүсэлтээ гаргасантай зэрэгцэн Авлигатай Тэмцэх Газраас түүнийг өөрийгөө тагнасан хэргээр шалгах аар болсныг мэдээлжээ.

Эргээд харахад 27 жилд МУ-д 17 удаа засгийн газар нь солигджээ. Үүнд 15 ерөнхий сайд, 2 үүрэг гүйцэтгэгч солигдсон байна. Үүнийг харахад ЗГ дунджаар 19 сарын хугацаатай байдаг байна. Энэ бүх ЗГ-аас 2 л ерөнхий сайд бүрэн хугацаагаа гүйцэтгэсэн байна. Уг үйл явдлыг гүнзгийрүүлж харахад зарим судлаачдын зүгээс уг ЗГ-т багтаж чадаагүй гишүүд өөрсдөө ЗГ-т багтах талаар ярьж байна. Зарим хэсэг нь ихээхэн хөрөнгө чинээтэй хүмүүс ЗГ-т багтдаг гэж байгаа бол нөгөө хэсэг нь одоогийн улс төрийн байдал

шинэчлэгдэх шаардлагатай гэж үзэж байна. Ямартай ч цаад шалтгааныг олон нийт эргэцүүлэн бодож байгаа. ЗГ-ыг огцруулах шаардлагагүй гэж үзэж байгаа хүмүүс эдийн засаг өсч байна, гадаадын хөрөнгө оруулалт ирэхгүй гэсэн байр суурьтай байна. Гэвч ЗГ-ыг огцруулах эсэх асуудлын гол суурь нь эдийн засаг биш юм. Энэ бол эрх мэдлийн төлөөх ээлжит өрсөлдөөн болж байна. Бидэнд уг өрсөлдөөн юу авчрах талаар асуудалд хандах шаардлагатай. Төр засаг тогтвортой бус байх нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, нийт бизнесийн уур амьсгалд эцэстээ нөлөөлдөг. Бизнесийнхэн төр засаг солигдож хууль журам ямар болох эсэхээс шалтгаалан хөрөнгө оруулалтаа хойшлуулдаг. Ялангуяа томоохон төслүүдэд оролцох хүсэлтэй байгаа гадаадын хөрөнгө оруулагчид бүр ч хойшлуулдаг. Учир нь томоохон төслүүдтэй холбоотойгоор ерөнхийдөө ЗГ-ыг огцруулж өөрчилж буй санагддаг. Том төсөл хийх гэж буй гадаадын компаниуд тогтвортой байдлын гэрээ заавал хийнэ гэдгийн цаад шалтгаан нь энэ юм. Энэ улсад

ямар нэг хэмжээгээр улс төрийн сүйрэл явагдаж байна гэж би үзэж байна. Учир нь хямралын суурийг үзэх юм бол эдийн засгийн суурь хямралтай хэвээр байна. ОУВС-ийн тусламжийн үр дүнд манай төсвийн алдагдал өмнөх жилтэй харьцуулахад 2 дахин багасчээ. Гэвч энэ нь эдийн засаг сэргэсэн гэсэн үг огтхон ч биш. Өнөөгийн эдийн засгийн бодлого ямар байна вэ? Хувийн хэвшлийн нөхцөл байдал сэргэсэн үү гэдэг л хамгийн чухал асуудал юм.

Том төслүүд эхлэхгүй байна. Учир нь төр засаг урт хугацаанд нийгэм-эдийн засагтай холбож харах боломж төр засагт байхгүй байна. Энэ бүхэн төр засагт байгаа хүмүүсийн ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой. Ийм ч учраас уг том төслүүд явадгүй. Үүний тод жишээ бол 5-р цахилгаан станцыг яриад 20 жил болж байна. Одоо ч хийх эсэх нь мэдэгдэхгүй байна. Өөр нэг тод жишээ бол хотын цэвэрлэх байгууламж. Жорлон нь хальчихсан айлд зочин болж ирэх хэцүү шүү дээ.

Багш нарын ажил хаялт

Багш нарын цалинг нэмэгдүүлэх түр хороо байгуулагдлаа, хэвлэлийн хурал зохион байгууллаа. Тэд 40 мянган багш нарын цалинг нэмэгдүүлэхийг шаардаж байна. ЗГ-т үүнтэй холбоотойгоор захидал илгээсэн ба үүнд одоогийн байдлаар 500-600 мянган төгрөгийн хооронд байгаа цалингийн хэмжээг 1.6 сая төгрөг болгох тухай тусгагджээ. Уг захидлын хариуд ЗГ-ийн зүгээс төсвийн алдагдал 2.4 тэрбум гэж батласан, хэрэв уг шаардлагыг биелүүлвэл энэхүү алдагдал 1.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэнэ, гэхдээ бид анхаарч ажиллана гэжээ. Одоогоор 16 мянган багш нар гарын үсэг зураад байна. Үүнийг харахад нэлээд томоохон хөдөлгөөн эхэлж байгааг харуулж байна. 9-р сарын 1-ээс өмнө Сүхбаатарын талбайд жагсаал хийх бөгөөд нийтээрээ оролцохыг уг хөдөлгөөний зүгээс уриалж байгаа юм байна. Төрийн албанд ажиллагсдын тоо 200 мянга орчим байдаг бол тэдний дөрөвний нэг нь багш нар байна. 2014 оны тоогоор нийт ерөнхий боловсролын сургуулиудын багш нарын тоо 30000 орчим, сургуулийн өмнөх

боловсролд 10000 гаруй нийтдээ 40000-өөд мянган багш ажилладаг байна. ЕБС-ийн багш нарын цалин дунджаар 550 мянган төгрөг, сургуулийн өмнөх боловсролын багш нарын дундаж цалин 488 мянган төгрөг байжээ.

МУ-ын дундаж цалин 900 мянган төгрөгбайнагэсэнстатистикмэдээлэл саяхан гарсан. Хөдөлмөрийн Судалгааны Институтээс 2013 онд гаргасан хүснэгтээр 2013 онд 642 мянган төгрөг байсан бол 4 жилийн дараагаар дээрх тоо гарсан байна. Үүнээс арай багавтар цалинтай нь боловсрол, боловсруулах үйлдвэр, хөдөө аж ахуйн салбар гэсэн байдлаар гарчээ. Харин хамгийн өндөр цалинтай нь уул уурхай, санхүүгийн даатгал, тээвэр, барилга, мэдээлэл холбоо байдаг байна.

Цалин нэмнэ гэвэл хаанаас нэмэх вэ гэдэг асуудал гарч байна. Аливаа улсын дундаж цалин хөдөлмөрийн бүтээмжээс хамаардаг. Гэвч Монголд энэ асуудал зөрчигдсөн. Төр засагт ажиллаж буй хүмүүсийн цалин өндөр байна гэж яригдаж байгаа. Гэхдээ хөдөлмөрийн бүтээмжийг нийт ажиллагсадтай харьцуулж үзэх

хэрэгтэй. Цалингийн доод хэмжээг тогтооход хувийн салбарынхан гүйцэхгүй байгаа. Тийм ч учраас хувийн салбарынхан ажилтан ажилд авахад идэвхтэй биш байгаа. Үүний цаад шалтгаан нь нэг талаас төрийн салбартай өрсөлдөж чадахгүй болж байна, нөгөө талаас төр өөрөө том болж байна. Уул уурхайн салбарт төр хамгийн том байр суурийг эзэлж байгаа. Төр бизнес хийх бус түүнийг хянах, стандарт тогтоох аюулгүй байдлыг, байгал хамгаалахыг эдийн засагт зөв нөлөө үзүүлэхийг хянах ёстой болохоос төр өөрөө ороод хийнэ гэдэг нь хувийн хэвшлийг боомилж байна. Хамгийн чухал ажил хийж буй багш, цагдаа нарын цалинг нэмэхэд төрийн нийт зардлаас хасч өгнө үү гэхээс биш хувийн салбарын татварыг өнгөрсөн 7 сард нэмдэг шиг байдлаар нэмж болохгүй. Үүнээс гадна хувийн сургуулиудад боломж олгох хэрэгтэй байна. Гэхдээ боломж олгоно гэдэг нь улсын сургуулиудтай адил төсвөөс мөнгө өгнө гэсэн үг биш юм. Учир нь төсөв хүүхдүүддээ хүрэхгүй байна. Хөдөөгүүр хүүхэдгүй сургуулиуд дүүрэн боллоо. Хотод сургуульгүй хүүхдүүд дүүрэн боллоо.

Францын “Engine” компани Монголд эрчим хүчний төсөл хэрэгжүүлнэ

Сайншандад салхины цахилгаан станцын компани санхүүжилттэй боллоо. Өнгөрсөн 7 хоногт 120 сая ам. долларын хөрөнгө оруулалт хийгдэхээр боллоо. Сайншандын салхин парк гэдэг ХХК Европын хөрөнгө оруулалтын банк, Европын сэргээн

босголт хөгжлийн банк зэргээс 47 болон 31 сая ам. долларыг авчээ. Энэ бол санхүүжилт амжилттай болоод буй 3 дахь компани болоод байна. Үүнээс гадна Төв, Өмнөговь аймгуудад байна. МУ 2020 он гэхэд бүх эрчим хүчнийхээ 20 хувийг, 2030 он гэхэд 30 хувь сэргээгдэх эрчим

хүч болгохоор Парисын хэлэлцээрт нэгдэж амлалт өгсөн. Chinese Machinery & Engineering гэдэг компани дээрх төслийг хийх юм байна.

Тоймын бүрэн эхийг <http://bit.ly/2wOEwis> холбоосоор үзнэ үү.

Та "Дефакто Газет" цахим сонинг тогтмол төлбөргүй хүлээн авахыг хүсвэл www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ үү.

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Дамбадаржаагийн Жаргалсайхан
Дангаасүрэнгийн Энхбат

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Ерөнхий редактор: Ганбаатарын Жавзмаа
Баг: Батхүүгийн Амар
Отгонбаярын Наранцацрал
Ганхуягийн Батхишиг
Энхбаярын Цоггэрэл

ХОЛБОО БАРИХ:

✉ editor1@jargaldefacto.com
☎ **+976-88003685**
🌐 www.defacto.mn